

БУУРАЛ ГАНДБАДРАА (VERONICA INCANA L) УРГАМЛЫН ХЭРЭГЛЭЭГ ЭМИЙН ЭРТНИЙ СУДАР НОМООС ТОДРУУЛАХ НЬ

Э.Сансархуяг¹, Т.Ариунжаргал², Д.Тунгалаг³,
Э.Сэлэнгэ⁴, Г.Одонтуяа⁵, Ш.Болд⁶,
^{1,2,3,4,5}ЭЗШУИС, ⁶МАУА

Abstract

ELUCIDATING THE USES OF THE PLANT VERONICA INCANA L FROM THE ANCIENT MEDICAL BOOKS

Sansarkhuyag.E¹, Ariunjargal.T², Tungalag.D³,
Selenge.E⁴, Odontuya.G⁵, Bold.Sh⁶

Mongolian University of Pharmaceutical Sciences^{1,2,3,4,5}
Mongolian Academy of Medical Science⁶

Background

Medicinal plant research has been successfully carried out in the field of pharmacy and pharmacology in Mongolia, and dozens of research projects are still being carried out. However, there are still fewer studied medicinal plants of practical importance growing in Mongolia. Therefore, there is a need to register and study the ancient medicinal books written by ancient Mongolian doctors about the relatively little-studied *Veronica Incana L* plant. In addition, taking into account that scientific research on *Veronica Incana L*, which grows in Mongolia, has not been done in the field of medicine, the topic was selected for research in this field.

Purpose

Comparing the information of the ancient medical books written by Mongolian doctors and scientists, who wrote about *Veronica Incana L*, to clarify the taste, power, and quality.

Research materials and methods

1. Research materials: Sumbe khamba Ishbaljir. gso dpyad bdud rtsi 'i chu rgyun gyi cha lag gi nang tshan gyi sman so so'i mngon brjod dang ngos 'dzin shel dkar me long. *Wooden printing block with Tibetan script*. Toin Jambaldorj. gso byed bdud rtsi 'i 'khrul med ngos 'dzin bzo rig me long du rnam par shar ba mdzes mtshar mig rgyan zhes bya ba bzhugs so. *Wooden printing block with Tibetan script*.
2. Research methods: Methods of textual analysis for ancient books and checklist methods were used in the study.

Conclusion

Gandhabhatra plant is used in traditional Mongolian medicinal practice from ancient times, the plant is called *Veronica Incana L* in Latin. Also called Buural gandbadraa in Mongolian. On the other hand, the traditional medical doctors of China's Inner Mongolia and Tibet use Gandbadraa, the Latin name *Gnaphalium affine D. Don*. The appearance, shape, and color of the flowers of these two plants are different. According to the research of the source, the main instruction and usage of the plants are the same: to destroy benign tumors, to remove poison, to treat colds, and to stop cough.

Keywords: medicinal plants, *Veronica Incana L*, traditional Mongolian medicine, ancient medicinal books



Оршил

Дорно дахины анагаах ухааны судар бичгийн түүхчилсэн тойм, ургамал амьтан, эрдсийн шинжлэх ухааны нэршлийг тодорхойлох, уламжлалт эмнэлэгт хэрэглэж ирсэн заалт, амт чадлыг нэгтгэн 100 гаруй ном, гарын авлага бичиж нийтийн хүртээл болгосон байна. Түүнчлэн олон арван зүйл ургамлын фитохимиин судалгааг манай судлаачид хийж гүйцэтгэснээс цахилдаг, хавраг, чонын өргөсний төрлийн ургамлаас өмнө нь тодорхойлогдоогүй байсан 60-аад уламжлалын бодисуудыг нээн илрүүлж тодорхойлсон байна. Тэдгээрийн 18-ийг нь сүүлийн 54 жилийн хугацаанд гадаадын эрдэмтэдтэй хамтран таньж тодорхойлж үр дүнгээ олон улсын нэр хүндтэй сэтгүүлд нийтлүүлж баталгаажуулсан байна. Д.Батсүрэн “Монгол орны зарим эмийн ургамлын фармакологийн идэвхт бодисын химиин судалгаа” (1992), С.Цэцэгмаа “Зарим зүйл ортуузын фитохими” (1992), Г.Чойжамц “Харлаг өмхий өвсний фармакологи” (1993), Л.Цэрэндулам “Бэришийн төрлийн ургамлын хими, хими технологи” (1995), Д.Дүнгэрдорж “Уламжлалт анагаах ухаанд хэрэглэгддэг өргөн тархсан зарим зүйл ургамлын фитохимиийн судалгааны үндсэн дээр шинэ эмийн бэлдмэл гарган авах асуудалд” (1996), Г.Одонтуяа “Монгол оронд ургадаг эвэрт сэرتэгийн газрын дээд хэсгийн альфа пироны уламжлалын нэгдлийн химиин судалгаа” (1997), Д.Энхжаргал “Ургамлын гаралтай зэхмэлбахурайхандээнийн фармакогнозын судалгаа” (2001), Б.Баясгалан “Монголын уламжлалт зарим эмийн чанарыг үнэлэх ба стандартчилыг боловсронгуй болгох асуудалд” (2001), С.Пүрэвсүрэн “Хоёр зүйл ортуузын хими” (2002) зэрэг олон чиглэлээр туурвисан судалгааны ажлуудыг нэрлэж болно¹. Эм зүй, эм судлалын салбарт энэ мэт амжилттай хэрэгжсэн судалгааны ажил цөөнгүй байв ч Монгол оронд ургадаг практик

ач холбогдолтой бага судлагдсан ургамлууд байсаар байна. Иймээс бид Буурал гандбадраа (*Veronica incana L*) тухай эмч маарамба нарын бичсэн судар номын бүртгэл, эрдэм судлалын ажил 20 дугаар зуунаас хойш анагаах ухааны салбарт бага хийгдсэнийг харгалзан үзэж энэ чиглэлээр судалгаа хийхээр уг сэдвийг сонгон авлаа.

Судалгааны ажлын зорилго

Буурал гандбадраа (*Veronica incana L*)-ийн талаар бичсэн монгол эмч, маарамба нарын эртний судар номын мэдээллийг харьцуулан судалж амт, чадал, чанар, эрдмийг тодруулах

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга

1. Судалгааны хэрэглэгдэхүүн

- Сүмбэ хамба Ишбалжир. “Анагаах засал рашааны урсгалын нэмэлт хэсгийн доторх эм тус бүрийг илт өгүүлэх хийгээд танин мэдэх цагаан болор толь хэмээх оршивай”. Модон барын төвөд судар (Хувийн номын санд хадгалагдаж байна)

-Тойн Жамбалдорж. Анагаан үйлдэх рашааныг эндуурэл үгүй танин мэдэх урлах ухааны толинд машид илэрсэн гайхамшигт үзэсгэлэнт нүдэн чимэг хэмээх оршивай (gso byed bdud rtsi'i 'khrul med ngos 'dzin bzo rig me long du rnam par shar ba mdzes mtshar mig rgyan zhes bya ba bzhugs so). Модон барын төвөд судар (Хувийн номын санд хадгалагдаж байна)

2. Судалгааны арга

- Эх зохиол судлах арга

Аливаа нэгэн судалгааны ажлыг хийхэд хамгийн түрүүнд хэрэглэгддэг арга нь эх зохиолыг судлах арга юм. Бид эрт цагийн маарамба, эмч, эрдэмтэн мэргэдийн бичиж туурвисан судар ном, эмийн бүтээлүүд зэрэг мэдээллийн эх сурвалжтай ажиллах үедээ уг аргыг ашиглав.

Судалгаа, шинжилгээ

- Харьцуулах арга

Харьцуулах гэдэг нь нэг үзэгдэл юмс нөгөө үзэгдэл юмсаас юугаараа ялгаатай, юугаараа адил төстэй болохыг танин мэдэж, тэдгээрийн нийтлэг ба онцлог шинжийг нээн харуулах боломж олгодог. Бид энэхүү аргыг ашиглан Буурал гандбадраа (*Veronica incana L.*)-гийн талаар бичсэн эмийн эртний судар номын мэдээллийг нэгтгэн дүгнэх бичигдсэн эртний судрыг харьцуулан судалж ялгаатай, төсөөтэй талыг тогтоов.

- Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга

Сурвалж бичгийн доторх Буурал гандбадраа (*Veronica incana L.*)-гийн талаар бичсэн эмийн эртний судар төрөлжүүлэн жагсааж, тэдгээрийг тодорхойлсон хэсгүүдийг бүрдүүлэхэд ашиглав. Магадлан жагсаах арга нь судлахууныг төрөлжүүлж ангилах, мэдээллийг цуглуулахад хялбар, үнэлгээний эхний шатны ажлыг гүйцэтгэх, төлөвлөсөн нийт ажлыг урьдчилан харах, цахим санд оруулахад зохимжтой, хялбар байдаг.

Судалгааны ажлын үр дүн

1990 оноос эхлэн Монгол Улсад уламжлалт анагаах ухааны их эмч бэлтгэх бодлого хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэ үеэс академич Ц.Хайдав, У.Лигаа, Б.Хүрэлчuluун, Ш.Болд, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Лувсан нарын бүтээл, төрийн болон хувийн хэвшлийн их, дээд сургуулийн уламжлалт анагаах ухааны ангид заах эм зүй, эм судлалын сурх бичгүүд хэвлэгдэж нийтийн хүртээл болсон. Эдгээр судлаачдын бүтээлийг нэгтгэн Буурал гандбадраа (*Veronica incana L.*)-гийн амт, чанар, чадал, үйлдлийг ерөнхийд нь тодруулав.

Монгол нэр: Буурал ганьбадраа

Санскрит нэр: गन्धभद्रा

Санскрит нэрний төвөд дуудлага ଗନ୍ଧଭଦ୍ର (gandhabhadra)

Латин: *Veronica incana L.*

Таван салаатны (Plantaginaceae) овогт хамаарах 20-50 см өндөр ургадаг олон наст өвслөг ургамал. Цайвар цагаан өнгийн иш, навчистай. Зууван юлдэн хэлбэрийн ишин дээр эсрэг сууж байрласан навчтай. Ургамлын бүх хэсэг эсгийлэг цагаан үсжилттэй. Цайвар хөх өнгийн сийрэг түрүү хэлбэрийн багцагтай.

Тархац: Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Дундад халх, Хянган, Ховд, Дорнот Монгол, Говь-Алтайн тойротг ойт хээр, хээрийн бүсэд хээржсэн хажуу, хээрийн нуга шинэсэн ойн захад ургана.

Эмийн түүхий эд: Газрын дээд хэсгийг хэрэглэнэ.

Агуулагдах бодис: Газрын дээрх хэсэгт апигенин, лютеолин, циноризид оролцсон флавоноид, алкалоид, кофеин болон хлорогенийн хүчлүүд агуулах бөгөөд кумарин, сапонин, иридоид агуулагдана. Зүрхний гликозид илрэх төдий, хөрсөн доорх эрхтэнд сапонин байна.

Амт, эрдэм: Иsgэлэн, эхүүн амттай, сэрүүн, хөнгөн, мохдог, эелдэг чанартай.

Чадал: Хаванг хатаах, өвдөхийг зогсоох, бөөлжихийг зогсоох, шар усыг арилгах чадалтай. Жор: Цомц-25, жамба-16, цомц-8 зэрэг жорын найрлагад орно².




Буурал гандбадраа (*Veronica incana L.*)



Сүмбэ хамба Ишбалжир

Ишбалжирын бичсэн "Анагаах засал рашааны урсгалын нэмэлт хэсгийн доторх эм тус бүрийг илт өгүүлэх хийгээд танин мэдэх цагаан болор толь хэмээх оршивай". Модон барын төвөд сударт Буурал гандбадраагийн талаар дараах мэдээллийг агуулж байна.



Гандабдар (噶丹巴达爾): дисан (噶丹巴達爾) хэмээх бөгөөд братог (噶丹巴達那)-гын зүйл болно.

Гандабадар (噶丹巴達爾) бол уулын жинстэй адил, урт шилбэтэй өвсөн эмийн зүйл болно.

Жахүр (噶丹巴達爾)-тэй адил нарийн навчтай шар зал шиг цэцэгтэй байдаг. Бас цайвар өнгөтэй, сайхан үнэртэй, сэвсгэр цэцэгтэй нэгэн зүйл байдаг. Энэхүү цагаан, шар хоёр зүйл бол бэтгийг эвдэх, цайвар бадган, тулай, бөөрний өвчин, дагшуур, хор зэрэгт тустай гэжээ³.

Тойн Жамбалдорж



Анагаан үйлдэх рашааныг эндүүрэл үгүй танин мэдэх урлах ухааны толинд машид илэрсэн гайхамшигт үзэсгэлэнт нүдэн чимэг хэмээх оршивай (gso byed

bdud rts'i'i 'khrul med ngos 'dzin bzo rig me long du rnam par shar ba mdzes mtshar mig rgyan zhes bya ba bzhugs so). Модон барын төвөд сударт:

Гандбадраа

Санскрит нэр: gandha bhatra

Хятад нэр: ling li'ng sh'ng

Санскрит нэртэй бөгөөд бөгөөд Төвөдөд

сайхан үнэрт хэмээмүй. Жахурадил боловч нарийн навчтай, урт эштэй, үрийн толгой нь ул өвс лүгээ адил, цайвар шаравтар бөгөөд дөрвөн хэлтэст цэцэгтэй, үнэр нь маш сайхан үнэртэй. "Болор бөмбөлөг"-т: "Гандабадраа нь бэтэг хийгээд бадганд тустай" хэмээн номложээ гэж тодорхойлсон байна⁴. Бид энэхүү эрдэмтний бүтээлд тулгуурласан Буурал гандбадраагийн мэдээллийг цааш нь гүнзгийрүүлэн БНХАУ-ын ӨМӨЗО, ТӨЗО-ны уламжлалт анагаах ухааны судлаачдын гол бүтээлд буй Гандбадраагийн мэдээлэлтэй харьцуулан үзлээ.

Буурал гандбадраагийн ялгаатай байдал БНХАУ-ын ӨМӨЗО-ны эм судлалын судлаачид Гандбадрааг Хибүргэнэ гэж нэрлэдэг. Үүнийг "Урт ургамлын зурагт толь" зэрэг ном бичигт тодорхой тэмдэглэж буй хэмээжээ⁵. Уг ургамал Удвал цэцгийн язгуурын хоёр наст өвслөг ургамал болох Хибүргэнэ, *Gnaphalium affine D. Don* болон нэг настай өвслөг ургамал болох чийгийн Хибүргэнэ, *Gnaphalium transschelli Kirp*-ийн хатаасан бүхэл өвс юм. Хибүргэнэ бол Дорнод орон, Өмнөд орон, Умард орон, Баруун өмнөд орон, Тайвань зэрэг муж орон, Солонгос, Япон, Вьетнам, Энэтхэгт гарна. Чийгийн Хибүргэнэ нь Өвөр Монгол, Зүүн хойд орон, Умард орон, ОХУ-ын Алс дорнод орон, Монгол, Япон, Солонгос, Өмнөд Америк тивд гарна. Дурс байдал нь сахлаг цайвар өвсөөр хучигдсан, нарийхан иш мэт цайвар улбар үндэстэй. Иш нь ёзоороосоо салаалж бутласан ба 15-30 см урт, диаметр нь 0.1-0.2 см. Ёзоорын навч цувран ургасан, навчны илтэс нь атирч үрчийсэн байдаг. Түүнийг усанд дэвтээгээд дэлгэвэл халбаган хэлбэртэй буюу дугариг хавтгай, бүслэг хавтгай, тонгоруу хавтгай хэлбэртэй, 2-6 см урт, 0.3-1 см өргөн, бүдүүн хөвөөтэй, хоёр тал нь эгц цайвар хөвөн үсээр бүрхэж байдаг. Алтан шар, шаравтар хүрэн буюу улбар шар өнгөтэй, нилээд арвин толгой

хэлбэртэй баг цэцэгтэй, ялимгүй үнэртэй. Зүн Хибүргэний цэцэглэсэн бүхэл өвсийг авч, хувхайрсан навчийг нь арилган хаяж, холимог юмсыг нь цэвэрлээд наранд хатаана.

Хибүргэнэ буюу гандбадраа бол гошуун, гашуун амттай. Бүлээн, ширүүн чанартай. Бэтгийг эвдэх, хорыг тайлах, бадгынг арилгах, ханиахыг зогсоох чадалтай. Эмчилгээнд хэрэглэхдээ:

1. Бэтгийг эвдэх үйлдэлтэй тул дотор хүйтэн бэтэг өвчинд тустай. Таван халуун эм, гурван үр, таван зүйлийн давс, тарианы хөө, Хибүргэнэ зэргийн түлсэн үнсийг Гаранзын найрлагатай хавсарч хэрэглэх буюу тасын баас, гурван халуун эм, таван зүйлийн давс, хөшигт үр зэрэгтэй хавсарч Наранагийн найрлагад хөл эм болгоно.
2. Хорыг тайлах үйлдэлтэй тул хорын өвчин архагшсанд тустай, бөхөнгийн эвэр, зидрага, баавгайн цөстэй найруулж, хороос болж хавагнасан хэсэгт нь түрхэнэ.
3. Ханиахыг зогсоох үйлдэлтэй тул тагшуурдаж ханиах, амьсгaa давхцах, дур булгихад тустай. Сүгмэл, габирын хальс, үзэм, шар чавга, библин зэрэгтэй хавсарч Сүгмэлийн үрэлд хөл болгоно.
4. Хибүргэнийг зургаан сайн эм, мөнгөн ус, Шар усны гурван эм, Доод гурван үр зэрэгтэй хавсарч Мөнгөн ус 25 д хөл болгож уяман өвчин, саа өвчин, хорын өвчин, тулай, хэрхэд хэрэглэдэг.
5. Хибүргэнийг хоёр зүйлийн зандан, гурван үр, гурван халуун эм, цагаан гич, бөөрөлзгөнө зэрэгтэй хавсарч Хүдэбийн тосон эмд хөл болгож солио өвчинд хэрэглэнэ.
6. Хибүргэнийг урт хошуут арүү, агширгана, жүүр үр, мана зэрэгтэй хавсарч Хибүргэний туулбарт хөл болгох буюу гүргэм, мана,

хулуу, жиданга, гоюу зэрэгтэй хавсарч Хибүргэний үрэлд хөл болгож цайвар хаван, суваг хаван, усан хаван өвчинд хэрэглэнэ. Эм зүйн судалгааг үндэслэвэл Хибүргэнэ нь цусны даралтыг бууруулах, цусан судлыг тэлүүлэх ба зүрхний хэмнэлийг удаан болгоно⁶.

Хэлцэмж

БНХАУ-ын ӨМӨЗО-ны эм судлалын судлаачид Гандбадрааг Хибүргэнэ гэж нэрлэдэг нь төвөд эмч нарын санскритаар *gandha patra*, *gandha bhatra*, латинаар *Gnaphalium affine*-ний навч, бүхэл өвсийг нь хэрэглэдэгтэй адил байна. Харин Монгол Улсад Гандбадрааг *Veronica incana L* гэж үзэн эмэнд хэрэглэдэг.

Сүмбэ хамба Ишбалжирын “Цагаан болор толь”-д “Бэтгийг эвдэх, цайвар бадган, тулай, бөөрний өвчин, дагшуур, хор зэрэгт тустай”, Тойн Жамбалдоржийн “Гайхамшигт үзэсгэлэнт нүдэн чимэг”-т “Гандбадраа нь бэтэг хийгээд бадганд тустай”⁸ гэсэн чадал, заалт нь Дундад улсын анагаах ухааны нэвтэрхий толь: Монгол анагаах ухаан номонд буй “Бэтгийг эвдэх, хорыг тайлах, бадгынг арилгах, ханиахыг зогсоох чадалтай” үндсэндээ яг тохирч байна⁹. Гэхдээ *Veronica incana L* болон *Gnaphalium affine* хоёрын гадад хэлбэр, өнгө ихээхэн ялгаатай байна.

БНХАУ-ын ӨМӨЗО-д хэвлэгдсэн Дундад улсын анагаах ухааны нэвтэрхий толь: Монгол анагаах ухаан номонд: “Хибүргэнэ, *Gnaphalium affine* бол Удвал цэцгийн язгуурын хоёр наст өвслөг ургамал, заримдаа *Gnaphalium tranzschelli Kirp*-ийн хатаасан бүхэл өвсийг” хэрэглэнэ гэж тэмдэглэсэн. БНХАУ-ын ТӨЗО-д хэвлэгдсэн “khrungs dpe dri med shel guyi me long” номонд Гандбадрааг *Gnaphalium affine D. Don* гэж бичсэн¹⁰ бөгөөд уг ургамлын гадаад шинж нь ӨМӨЗО-ны судлаачдын тодорхойлолттой үндсэндээ адил байна.



Тухайлбал: “Дүрс байдал нь сахлаг цайвар өвсөөр хучигдсан байдаг. Нарийхан иш мэт цайвар улбар үндэстэй. Иш нь ёзоороосоо салаалж бутласан ба 15-30 см урт, диаметр нь 0.1-0.2 см, ёзоорын навч цувран ургасан, навчны илтэс нь атирч үрчийсэн байдаг. 2-6 см урт, 0.3-1 см өргөн, бүдүүн хөвөөтэй, хоёр тал нь эгц цайвар хөвөн үсээр бүрхсэн, алтан шар, шаравтар хүрэн буюу улбар шар өнгөтэй, нэлээд арвин толгой хэлбэртэй баг цэцэгтэй, ялимгүй үнэртэй” гэжээ.

Гэтэл Монгол Улсад ургадаг Гандбадрааг (*Veronica incana L.*) Таван салаатны (*Plantaginaceae*) овогт хамаарах 20-50 см өндөр ургадаг олон наст өвслөг ургамал бөгөөд цайвар цагаан өнгийн иш, навчистай, зууван юлдэн хэлбэрийн ишин дээр эсрэг сууж байрласан навчтай. Ургамлын бүх хэсэг эсгийлэг цагаан үсжилттэй. Цайвар хөх өнгийн сийрэг түрүү

хэлбэрийн багцагтай гэж тодорхойлсон байна¹¹.

Судалгааны үр дүнд бид монгол эмч маарамбууд хуучин цагт Энэтхэг, Төвөдөд ургадаг эмийн ургамлуудын олдоц муу, чанартай холбоотойгоор гадаадаас авдаг эмийн ургамлыг өөрийн оронд ургадаг эмийн ургамлаар орлуулан хэрэглэх явдал түгээмэл байжээ гэдгийг улам бататгасан. Ингэж орлуулан хэрэглэхдээ гадаад хэлбэр, дүрс, цэцэгний өнгөөр нь бус уг ургамалд агуулагдаж байгаа эмийн үйлдэл голлон үзүүлдэг, амт, чанар, чадал, эрдэм гэсэн шалгуураар адилтган үзэж хэрэглэдэг байжээ. БНХАУ-ын ӨМӨЗО, ТӨЗО-д ургадаг Гандбадраа (*Gnaphalium affine D. Don*)-гийн дүрс, хэлбэр, цэцэгний өнгө нь өөр ч гэсэн бэлгийг эвдэх, хорыг тайлах, бадганыг арилгах, ханиахыг зогсоох чадал нь адил байна. Мөн МҮ-д



Зураг 2. Гандбадраагийн ялгаатай байдал.

Зүүн гар талд МҮ-д ургадаг Буурал гандбадраа (*Veronica incana L.*)-гийн, Баруун гар талд нь БНХАУ-ын ӨМӨЗО, ТӨЗО-д ургадаг Гандбадраа (*Gnaphalium affine D. Don*)-гийн дүрс

Судалгаа, шинжилгээ

Буурал гандбадраа гэж монголчлон нэрлэдэг бол БНХАУ-ын ӨМӨЗО-д Гандбадраа буюу Хибүргэнэ гэж нэрлэдэг ажээ.

Дүгнэлт

Гандбадраа ургамлыг Монгол Улсын уламжлалт анагаах ухааны практикт латинаар *Veronica incana L* гэж нэрлэдэг ургамлыг хэрэглэдэг бөгөөд Буурал гандбадраа гэж нэрлэдэг. Нөгөө талаар БНХАУ-ын ӨМӨЗО, ТӨЗО-ны уламжлалт эмнэлгийн эмч нар Гандбадраа, латин нэр нь *Gnaphalium affine D. Don*-ийг хэрэглэдэг. Энэ хоёр ургамлын гадаад байдал, дүрс, цэцэгний өнгө өөр байна. Харин эмийн ургамлын гол үзүүлэлт бэтгийг эвдэх, хорыг тайлах, бадганыг арилгах, ханиахыг зогсоох гэсэн чадал, эрдмийн хувьд адилхан байгаа нь сурвалжийн судалгаагаар тогтоогдлоо.

Ном зүй

1. Сансархуяг Э., Үе мөчний өвчинд Буурал гандбадраа ургамлын үзүүлэх үйлдлийг тогтоох нь. Эм зүйн ухааны докторын зэрэг (Ph.D) горилох нэг сэдэвт бүтээлийн сэдэв, аргазүй. 2022
2. Болд Ш., Монголын уламжлалт анагаах ухааны эм судлал. 2014, 201.
3. Сүмбэ хамба Ишбалжир. Ишбалжир. “Анагаах засал рашааны урсгалын нэмэлт хэсгийн доторх эм тус бурийг илт өгүүлэх хийгээд танин мэдэх цагаан болор толь хэмээх оршивай”. Модон барын төвөд судар.
4. Тойн Жамбалдорж. Анагаан үйлдэх рашааныг эндүүрэл үгүй танин мэдэх урлах ухааны толинд машид илэрсэн гайхамшигт үзэсгэлэнт нүдэн чимэг хэмээх оршивай (gso byed bdud rtsi'i 'khrul med ngos 'dzin bzo rig me long du rnam par shar ba mdzes mtshar mig rgyan zhes bya ba bzhugs so). Модон барын төвөд судар.
5. Дундад улсын анагаах ухааны нэвтэрхий толь: Монгол анагаах ухаан. ӨМ-ын ШУТМ-ийн Хэвлэлийн хороо. 1986, 530
6. Дундад улсын анагаах ухааны нэвтэрхий толь: Монгол анагаах ухаан. ӨМ-ын ШУТМ-ийн Хэвлэлийн хороо. 1986, 530-531
7. Сүмбэ хамба Ишбалжир. Ишбалжир. “Анагаах засал рашааны урсгалын нэмэлт хэсгийн доторх эм тус бурийг илт өгүүлэх хийгээд танин мэдэх цагаан болор толь хэмээх оршивай”. Модон барын төвөд судар.
8. Тойн Жамбалдорж. Анагаан үйлдэх рашааныг эндүүрэл үгүй танин мэдэх урлах ухааны толинд машид илэрсэн гайхамшигт үзэсгэлэнт нүдэн чимэг хэмээх оршивай (gso byed bdud rtsi'i 'khrul med ngos 'dzin bzo rig me long du rnam par shar ba mdzes mtshar mig rgyan zhes bya ba bzhugs so). Модон барын төвөд судар.
9. Дундад улсын анагаах ухааны нэвтэрхий толь: Монгол анагаах ухаан. ӨМ-ын ШУТМ-ийн Хэвлэлийн хороо. 1986, 530.
10. 'Khrungs dpe dri med shel gyi me long. Ард хэвлэлийн хороо, 1995, 182.
11. Болд Ш., Монголын уламжлалт анагаах ухааны эм судлал. 2014, 201.

*Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
АУ-ы доктор, профессор З.Ариунаа*